

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3.Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	14
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	15
4. Менежментийн захидал	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.03.25 № 01/998

танай _____-ны № _____-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
Л.БЯМБАСҮРЭН ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Эрүүл мэндийн даатгалын 1 зорилтын хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 175,896.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн "Тохиолдсон байх", "Үнэн зөв байдал", "Толилуулга ба тодруулга", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

\\10.10.10.20\Bksho_Khered\Yawsen_Bksho\2021\0325\audit\in 2-R_Gazar20.Docx

001052269

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант он: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	738,141,495,167.1	797,221,449,862.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	557,520,331,504.4	617,256,242,124.0
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	324,520,331,504.4	267,256,242,124.0
3121	Төгрөг	324,520,331,504.4	267,256,242,124.0
31211	Төрийн сангийн харилцах	35,693,520,097.8	99,095,298,575.6
31213	Арилжааны банк дахь харилцах	288,826,811,406.6	158,560,943,548.4
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	9,600,000,000.0
31500	Хадгаламж	233,000,000,000.0	350,000,000,000.0
33	АВЛАГА	180,122,663,075.7	176,856,872,315.3
33300	Татаас, санхүүжилтийн авлага	26,495,352,151.5	26,495,356,151.5
335	Бусад авлага	153,627,310,924.2	150,361,516,163.8
3351	Байгууллагаас авах авлага	153,627,310,924.2	150,361,516,163.8
34	УРЬДЧИЛГАА	498,500,587.0	3,108,335,423.2
34600	Урьдчилж гарсан зардал	498,500,587.0	3,108,335,423.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	738,141,495,167.1	797,221,449,862.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,657,304,778.0	2,615,730,575.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,657,304,778.0	2,615,730,575.7
413	Өглөг	2,650,745,853.0	2,615,569,155.7
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	2,546,620,780.4	2,546,620,780.4
4136	Бусад өглөг	104,125,072.6	68,948,375.3
41361	Байгууллагад төлөх өглөг	104,125,072.6	68,948,375.3
414	Урьдчилж орсон орлого	6,558,925.0	161,420.0
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	-	161,420.0
41440	Бусад урьдчилж орсон орлого	6,558,925.0	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	735,484,190,389.1	794,605,719,286.7
51	Засгийн газрын хувь оролцоо	735,484,190,389.1	794,605,719,286.7
512	Хуримтлагдсан үр дүн	735,484,190,389.1	794,605,719,286.7
51210	Өмнөх үеийн үр дүн	589,340,157,524.4	735,484,190,389.1
51220	Тайлант үеийн үр дүн	146,144,032,864.7	59,121,528,897.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	738,141,495,167.1	797,221,449,862.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант он: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	494,850,381,506.0	473,261,805,434.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	103,584,790,363.0	84,022,693,093.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	103,584,790,363.0	84,022,693,093.0
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	103,584,790,363.0	84,022,693,093.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,679,379,233.5	51,052,960,369.4
120	Нийтлэг татварын бус орлого	51,679,379,233.5	51,052,960,369.4
120002	Хүүгийн орлого	49,807,221,703.5	50,872,524,200.8
120003	Торгуулийн орлого	1,869,829,930.0	180,436,168.6
120009	Бусад орлого	2,327,600.0	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	339,586,211,909.5	338,186,151,971.8
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	339,586,211,909.5	338,186,151,971.8
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	339,586,211,909.5	338,186,151,971.8

2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	348,706,348,641.3	414,140,276,536.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	348,706,348,641.3	414,140,276,536.6
212	ТАТААС	40,613,561,803.8	41,088,538,942.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	40,613,561,803.8	41,088,538,942.0
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	40,613,561,803.8	41,088,538,942.0
21220101	Эмийн зардал - ЭМДС	33,470,855,266.6	35,898,126,260.0
21220102	Эмийн зардал Элэг бүтэн С эм-	5,447,575,239.0	3,198,300,795.0
21220103	Эмийн зардал Элэг бүтэн В эм	1,695,131,298.2	1,992,111,887.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	308,092,786,837.5	373,051,737,594.6
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	303,902,060,605.5	366,996,163,666.3
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	303,902,060,605.5	366,996,163,666.3
21310101	Улсын Эмнэлгийн үйлчилгээ - ЭМДС	236,842,346,831.0	265,736,434,373.2
21310102	Сувилалын үйлчилгээ - ЭМДС	10,683,564,163.0	21,097,999,859.0
21310105	Элэг бүтэн С тоолох - ЭМДС	5,341,460,000.0	3,395,120,000.0
21310106	Элэг бүтэн Урьдчилан сэргийлэх - ЭМДС	4,013,672,500.0	6,559,153,040.0
21310107	Хувийн Эмнэлгийн үйлчилгээ - ЭМДС	37,310,550,929.5	58,012,196,190.1
21310108	Элэг бүтэн-В, С Эрт илрүүлэг	721,258,660.0	473,107,500.0
21310109	Элэг бүтэн-В, С баталгаажуулах шинжилгээ	15,118,000.0	11,699,000.0
21310113	Өрхийн эмнэлгийн үйлчилгээ - ЭМДС	4,082,810,504.0	4,514,657,283.0
21310114	СЭМТ - ЭМДС	4,891,279,018.0	7,187,876,421.0
21310119	Фитнес клубын зардал	0.0	7,920,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	259,043,941.3	201,562,683.2
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	259,043,941.3	201,562,683.2
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,931,682,290.7	5,854,011,245.1
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,931,682,290.7	4,754,011,245.1
21330101	Төсөвт үйл ажиллагааны зардлын - ЭМДС	3,699,297,575.4	4,514,670,541.5
21330102	Төсөвт үйл ажиллагааны зардлын - ЭМДҮЗ	232,384,715.3	239,340,703.6
21330103	НДЕГ-н үйл ажиллагааны санхүүжилт	0.0	1,100,000,000.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	146,144,032,864.7	59,121,528,897.7
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	146,144,032,864.7	59,121,528,897.7

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант он: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	469,617,770,116.4	486,115,442,860.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	83,804,450,135.0	84,016,130,168.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	83,804,450,135.0	84,016,130,168.0
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	83,804,450,135.0	84,016,130,168.0
1120051	Төр хариуцах иргэдийн ЭМДаатгал	83,804,126,505.0	84,016,130,168.0
11200601	ХНХЯамнаас шилжүүлэх	83,101,923,800.0	83,101,923,800.0
11200602	БХЯамнаас шилжүүлэх	218,676,400.0	301,111,200.0
11200603	ХЗЯамнаас шилжүүлэх	483,526,305.0	613,095,168.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	42,735,609,918.2	65,604,561,488.5
120	Нийтлэг татварын бус орлого	42,735,609,918.2	65,604,561,488.5
120002	Хүүгийн орлого	42,538,772,388.2	54,993,946,118.6
12000201	Хадгаламжийн хүүгийн орлого	33,112,436,095.7	48,711,430,137.0
12000203	Харилцахын хүүгийн орлого	9,426,336,292.5	6,282,515,981.6
120003	Торгуулийн орлого	194,509,930.0	180,436,168.5
12000301	Актын төлбөр ЭМДЕГ	162,577,020.0	180,436,168.5
12000302	Актын төлбөр НДЕГ	31,932,910.0	0
12000910	Сангийн бусад орлого	2,327,600.0	10,430,179,201.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	343,077,710,063.1	336,494,751,203.8
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	343,077,710,063.1	336,494,751,203.8
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	343,077,710,063.1	336,494,751,203.8
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	350,319,184,174.1	426,379,532,240.7

21	УРСГАЛ ЗАРДАЛ	350,319,184,174.1	426,379,532,240.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	525870.61	9,600,000,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	525,870.61	9,600,000,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	9,600,000,000.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	525,870.61	-
212	ТАТААС	40,549,224,530.1	41,108,635,128.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	40,549,224,530.1	41,108,635,128.0
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	40,549,224,530.1	41,108,635,128.0
21310103	Эмийн зардал	33,402,348,218.9	35,926,617,526.0
21310104	Элэг бүтэн С эм	5,449,845,239.0	3,189,830,795.0
21310112	Элэг бүтэн В эм	1,697,031,072.2	1,992,186,807.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	309,769,433,773.4	375,670,897,112.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	305,578,707,541.4	369,607,403,184.4
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	305,578,707,541.4	369,607,403,184.4
21310101	Эмнэлгийн үйлчилгээ /Улсын эмнэлэг/	236,812,201,563.9	268,376,050,091.3
21310102	Сувилалын үйлчилгээний зардал	10,597,914,163.0	21,105,549,859.0
21310105	Элэг бүтэн С тоолох	7,244,631,000.0	3,395,360,000.0
21310106	Элэг бүтэн урьдчилан сэргийлэх	3,925,321,898.0	6,558,012,000.0
21310107	Эмнэлгийн үйлчилгээ /Хувийн эмнэлэг/	37,325,905,706.5	57,997,389,920.1
21310108	Элэгний В, С вирусн илрүүлэг	671,423,808.0	472,883,490.0
21310109	Элэгний В,С вирусийн баталгаажуулах шинжилгээ	15,118,000.0	11,699,000.0
21310113	ӨЭМТ	4,085,248,004.0	4,512,246,783.0
21310114	СЭМТ	4,900,943,398.0	7,178,212,041.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	259,043,941.3	209,482,683.1
21320202	Илүү төлсөн шимтгэлийн буцаалт	259,043,941.3	201,562,683.1
21320201	Төрөл сольсон шимтгэлийн буцаалт	-	7,920,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,931,682,290.7	5,854,011,245.1
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,931,682,290.7	5,854,011,245.1
29998001	Үйл ажиллагаа ЭМДЕГ	3,699,297,575.4	4,514,670,541.5
29998002	Үйл ажиллагаа ЭМДҮЗ	232,384,715.3	239,340,703.6
21330103	НДЕГ-т олгох санхүүжилт	-	1,100,000,000.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	119,298,585,942.3	59,735,910,619.6
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	-
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	136,113,246,755.6	-
2200	Дотоод эх үүсвэр	136,113,246,755.6	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-136,113,246,755.6	-
7	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-16,814,660,813.3	59,735,910,619.6
8	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	574,334,992,317.7	557,520,331,504.4
9	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	557,520,331,504.4	617,256,242,124.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант он: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгэ эний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	588,576,766,292.4	-	588,576,766,292.4
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	763,391,232.0	-	763,391,232.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	589,340,157,524.4	-	589,340,157,524.4
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	146,144,032,864.7	-	146,144,032,864.7
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	735,484,190,389.1	-	735,484,190,389.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	735,484,190,389.1	-	735,484,190,389.1
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	59,121,528,897.7	-	59,121,528,897.7
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	794,605,719,286.7	-	794,605,719,286.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант он: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	557,520,331,504.3		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	494,538,344,100.0	426,387,452,240.7	68,150,891,859.2	86.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	494,538,344,100.0	426,387,452,240.7	68,150,891,859.2	86.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,000,000,000.0	9,600,000,000.0	10,400,000,000.0	48.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,000,000,000.0	9,600,000,000.0	10,400,000,000.0	48.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,000,000,000.0	9,600,000,000.0	10,400,000,000.0	48.0
212	ТАТААС	50,335,799,000.0	41,108,635,128.0	9,227,163,872.0	81.7
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	50,335,799,000.0	41,108,635,128.0	9,227,163,872.0	81.7
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	50,335,799,000.0	41,108,635,128.0	9,227,163,872.0	81.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	424,202,545,100.0	375,678,817,112.7	48,523,727,987.2	88.6
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	418,524,126,500.0	370,720,243,184.4	47,803,883,315.5	88.6
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	418,524,126,500.0	370,720,243,184.4	47,803,883,315.5	88.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	240,000,000.0	201,562,683.1	38,437,316.8	84.0
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	240,000,000.0	201,562,683.1	38,437,316.8	84.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,438,418,600.0	4,757,011,245.1	681,407,354.8	87.5
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,438,418,600.0	4,757,011,245.1	681,407,354.8	87.5
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	494,538,344,100.0	486,115,442,860.3	8,422,901,239.6	98.3
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	436,903,774,868.5	431,121,496,741.7	5,782,278,126.7	98.7
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	436,903,774,868.5	431,121,496,741.7	5,782,278,126.7	98.7
120	Нийтлэг татварын бус орлого	57,634,569,231.5	54,993,946,118.6	2,640,623,112.8	95.4
120002	Хүүгийн орлого	57,634,569,231.5	54,993,946,118.6	2,640,623,112.8	95.4
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	607,648,322,123.9	607,648,322,123.9	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
610001	Төсвийн байгууллага	1	1	-	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	-	160	160	
620001	Удирдах ажилтан		3	3	
620002	Гүйцэтгэх ажилтан		157	157	

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын дүнд үндэслэн шалгагдагч этгээдэд авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулах арга хэмжээ авч ажиллах, төсвийг үнэн бодитой, үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, гэрээт ажилчидтай хийсэн хөдөлмөрийн гэрээг хууль, журамд нийцүүлэн байгуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 05-наас 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор Р.Цолмон, аудитор П.Амарсанаа, Э.Энхбаатар, гэрээт ажилтан М.Ганбаатар нар гүйцэтгэв.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/295 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээ худалдан авдаг, хэрэглэгч, үйлчлүүлэгч төвтэй, нийгмийн хариуцлага бүхий эрүүл мэндийн даатгалын бие даасан тогтолцоог бүрдүүлэх;
- Байгууллагын дотоод, гадаад харилцааг өргөжүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалан даатгуулагч төвтэй, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх;
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь даатгуулагчдад нээлттэй, ил тод, хариуцлагатай байдлыг хангаж сайн засаглалын зарчмыг баримталж, даатгуулагчийн эрхийг дээдэлсэн, тэдний эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн, чанартай, үр дүнтэй, аюулгүй тусламж, үйлчилгээг үзүүлж, болзошгүй санхүүгийн эрсдэлээс хамгаалах;
- Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа нь нотолгоонд тулгуурласан, нийгмийн түншлэл, зөвшилцлийг хангахуйц байнгын тасралтгүй байх;
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар болон салбар нэгжүүдтэй холбогдсон мэдээллийн нэгдсэн цахим сүлжээ, мэдээллийн цахим сан бүрдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын тухай /Шинэчилсэн найруулга/;
- Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, төрийн санд байршуулах, зарцуулах журам;
- Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль;

- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай;
- Сангийн сайдын 74 дүгээр тушаалаар батлагдсан Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, няравт тавих журам батлах тухай.

Мөн дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахалтай холбоотой дараах Засгийн газрын тогтоолууд гарсан байна. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай Засгийн газрын 187 дугаар тогтоол;
- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 78 дугаар тогтоол;
- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 114 дүгээр тогтоол;
- Ковид-19 цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 168 дугаар тогтоол;
- Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний Засгийн газрын 183 дугаар тогтоол.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Эрүүл мэндийн даатгалын сан нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын сан нь дотоод аудиторгүй тул дотоод хяналт, шалгалт хийгээгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 473,261.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4,732.6 сая төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 59,079.9 сая төгрөгөөр буюу 8.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	557,520,331.5	617,256,242.1	59,735,910.6
Авлага	180,122,663.1	176,856,872.3	(3,265,790.8)
Урьдчилгаа	498,500.6	3,108,335.4	2,609,834.8
Нийт хөрөнгө	738,141,495.2	797,221,449.9	59,079,954.7
Өр төлбөр	2,650,745.9	2,615,569.2	(35,176.7)
Урьдчилж орсон орлого	6,558.9	161.4	(6,397.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	735,484,190.4	794,605,719.3	59,121,528.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	738,141,495.2	797,221,449.9	59,079,954.7

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 108,695.2 сая төгрөг төрийн сангийн харилцахад, 158,560.9 сая төгрөг арилжааны банкны харилцахад тус тус байршиж байна. Мөн мөнгөн хөрөнгө 59,735.9 сая төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын зарцуулаагүй үлдэгдэл болон хадгаламжийн хүүгийн орлогыг ЭМДС-д төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хадгаламжийн үлдэгдэл Улаанбаатар банкны хадгаламжид 10,000.0 сая төгрөг, Капитрон банкны хадгаламжид 10,000.0 сая төгрөг, Хас банкны хадгаламжид 20,000.0 сая төгрөг, Голомт банканд 40,000.0 сая төгрөг, Төрийн банкны хадгаламжид 45,000.0 сая төгрөг, Худалдаа, хөгжлийн банкны хадгаламжид 110,000.0 сая төгрөг, Хаан банкны хадгаламжид 115,000.0 сая төгрөгийн хадгаламж байна.

ЭМДҮЗ-ийн 2020 оны дугаар 03 “Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг банканд хадгалуулах тухай” тогтоолоор дээрх эх үүсвэрийг банканд байршуулж Эрүүл мэндийн даатгалын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6-д “сангийн чөлөөт үлдэгдлийн хүү”-ийн орлогыг санд төвлөрүүлэн ажилласан байна.

Авлага 176,856.8 сая төгрөг болж 3,265.7 сая төгрөгөөр буурсан. Мөн олон жилийн насжилттай дараах авлага байна. Тухайлбал:

- 2018 онд НДЕГ-аас шилжиж ирсэн ХНХЯ-аас авах 4,388.2 сая төгрөг, НДЕГ-аас шилжиж ирсэн “Эрүүл хүүхэд, эрүүл шүд хөтөлбөр”-ийн хүрээнд бий болсон дүүрэг, аймгуудын эрүүл мэндийн байгууллагуудаас авах 444.0 сая, Капитал банканд байршуулж байсан чөлөөт эх үүсвэртэй холбоотой тус банкны төлбөр барагдуулах чадваргүй болсноос үүссэн 135,290.0 сая төгрөг;
- 2018, 2019 онд үүссэн ХНХЯ-аас авах төр хариуцах иргэдийн 22,107.1 сая төгрөгийн материаллаг дүнтэй авлагууд байгаа нь цаашид барагдахгүй, олон жилийн насжилттай авлага үүсэх эрсдэлтэй байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 3,108.3 сая төгрөг болж 2,609.8 сая төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас өндөр өртөгт, тусламж үйлчилгээний урьдчилгаа санхүүжилт авсан боловч Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж үйл ажиллагаа хязгаарлагдсан дараах эрүүл мэндийн байгууллагуудын үлдэгдэлтэй холбоотой байна. Тухайлбал: Цэргийн төв эмнэлэг 1,740.4 сая, Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг 722.1 сая төгрөг, Халдварт өвчин судлалын үндэсний төв 119.9 сая, Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг 59.7 сая төгрөг.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,615.8 мянган төгрөг болж 41.4 сая төгрөгөөр буурсан нь байгууллагад өгөх өглөг барагдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 794,605.7 сая төгрөг болж 59,121.5 сая төгрөгөөр өссөн нь сангийн мөнгөн хөрөнгийн хэмжээ өссөнөөс шалтгаалжээ.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 16,497.6 сая төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого нь Ковид-19 цар тахлын үеийн эдийн засгийн зогсонги байдалтай холбоотой хөнгөлөлт, чөлөөлөлтөөс шалтгаалан 19,562.1 сая төгрөгөөр буурсан;
- Торгуулийн орлого- 1,692.9 мянган төгрөгөөр буурсан;
- Хүүгийн орлого- 1,065.3 мянган төгрөгөөр өссөн;
- Нийгмийн даатгалын сангаа санхүүжих орлого- 6,376.2 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 65,433.9 сая төгрөгөөр буюу 18.7 хувиар буурсан байна. Үүнд:

Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас- 474.9 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Эмийн зардал - 2,427.2 сая төгрөгөөр өссөн;
- Эмийн зардал Элэг бүтэн В эм- 296.9 сая төгрөгөөр буурсан байна.
- Эмийн зардал Элэг бүтэн С эм- 2,249.2 сая төгрөгөөр өссөн.

Засгийн газрын урсгал шилжүүлэг- 63,094.1 сая төгрөгөөр байна. Үүнд:

- Улсын эмнэлгийн үйлчилгээ- 28,894.0 сая төгрөгөөр өссөн;
- Сувиллын үйлчилгээ- 10,414.4 сая төгрөгөөр өссөн;
- Элэг бүтэн урьдчилан сэргийлэх- 2,545.4 сая төгрөгөөр өссөн;
- Хувийн эмнэлгийн үйлчилгээ- 20,701.6 сая төгрөгөөр өссөн;
- Өрхийн эмнэлгийн үйлчилгээ- 432.0 сая төгрөгөөр өссөн;
- Фитнес клубийн зардал- 7.9 сая төгрөгөөр өссөн;
- Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн зардал- 2,296.6
- Элэг бүтэн С тоолох зардал- 1,946.3 сая төгрөгөөр буурсан;
- Элэг бүтэн В,С эрт илрүүлэлт- 248.1 сая төгрөгөөр буурсан;
- Элэг бүтэн В,С баталгаажуулах шинжилгээний зардал- 3.4 сая төгрөгөөр буурсан.

Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардал- 57.4 сая төгрөгөөр буурсан байна.

ЭМДС-аас үйл ажиллагаанд олгох санхүүжилт, шилжүүлэг- 1,922.3 сая төгрөгөөр буурсан нь: Урсгал үйл ажиллагааны санхүүжилт 822.3 сая, НДЕГ-ын үйл ажиллагааны санхүүжилт- 1,100.0 сая төгрөг буурснаас шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 527,868.6 сая төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 21,330.3 сая төгрөгөөр бууруулж 506,538.3 мянган төгрөгөөр баталсан байгаа нь хувийн эмнэлэг, эмийн санд олгох татаас, урсгал үйл ажиллагааны санхүүжилттэй холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг хэрэгжүүлэх 494,538.4 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс 431,121.4 сая төгрөгийн санхүүжилт авч, чөлөөт эх үүсвэрийг байршуулснаас хүүгийн орлого 54,993.9 сая төгрөг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 426,387.4 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь ЭМДС-аас санхүүжих эмийн зардал арга хэмжээнээс- 7,302.1 сая төгрөг, элэг бүтэн Монгол хөтөлбөрийн эмийн үнийн хөнгөлөлт арга хэмжээнээс- 1,924.9 сая, ЭМДС-аас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилт арга хэмжээнээс- 19,922.4 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилт арга хэмжээнээс- 21,743.3 сая, элэг бүтэн Монгол хөтөлбөр шинжилгээ арга хэмжээнээс- 1,572.4 сая, Өрх, сумд ЭМД-аас олгох санхүүжилт арга хэмжээнээс- 2,671.9 сая, ЭМДС-аас төрийн өмчит аж ахуй нэгжүүдэд өгөх шилжүүлэг арга хэмжээнээс- 369.5 сая төгрөг, Урсгал үйл ажиллагааны санхүүжилт- 681.4 сая, суманд ЭМД-аас олгох санхүүжилт арга хэмжээнээс- 1,529.1 сая, ндш-ийн илүү төлөлтийн буцаалт арга хэмжээнээс- 38.4 сая, эрсдэлийн сангийн нөөц хөрөнгө арга хэмжээнээс- 10,400.0 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 163 мэдээллээс хугацаандаа оруулсан 67 мэдээлэл, хугацаа хоцроосон 93 мэдээлэл, огт оруулаагүй 3 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 16.4 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 53,917.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 36,325.7 сая төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 27.8 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	16.4	1	16.4	1	16.4	100.0
Албан шаардлага	1	53,917.4	1	53,917.4	1	53,917.4	100.0
Зөвлөмж	5	36,625.7	5	36,625.7	4	10,124.5	27.8
Нийт дүн	7	90,259.5	7	90,259.5	6	64,058.3	75.9

/сая.төг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 183,660.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7,763.9 сая төгрөгийн алдааг залруулж, 26,710.7 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 149,186.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Өмнөх онд үүссэн НДЕГ-аас 7,776.3 сая төгрөгийн дансны авлагыг шууд орлогоор бүртгэж, авлага бууруулахгүй тайлагнасан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар илэрсэн 26,710.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 албан шаардлага хүргүүлэв.

1. Өмнөх оноос шилжиж ирсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас авах төр төлбөрийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын 26,501.2 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй. Мөн Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам руу удаа дараа тооцоо нийлэх хүсэлт явуулсан ч үндэслэлгүй авлага үүсгэсэн, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулж ажиллах талаар хариу өгсөн байна. Дээрх авлага нь цаашид барагдахгүй, олон жилийн насжилттай авлага үүсэх, жил бүрийн аудитаар санхүүгийн тайланг хязгаарлах үндэслэл болох эрсдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2 “Өр, авлага үүсгэхгүй байх” гэж заасны хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

2. Тайлант оны эцэст 13.4 сая төгрөгийн шатахуун худалдан авч нөөц үүсгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3. Байгууллагын дотоод журамд заагдсаны дагуу ажиллагсдын их, дээд сургуульд сурсны төлбөрийг олгохдоо сургалтын төлөвлөгөөг үндэслэн гэрээ байгуулаагүй байна. Мөн журамд заагаагүй TOEFL /гадаадын их дээд сургуульд элсэх/ англи хэлний шалгалтын төлбөр 4,000,000 /Дөрвөн сая/ төгрөгийг олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.1 "Анхан шатны баримт бүрдүүлэх", Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлах тухай 2020 оны А/141 тушаалын 9.9.1 “Удирдлагын академи болон төрийн өмчит, их дээд сургуулийн мэргэшүүлэх, магистр, докторын түвшний сургалтын төлбөрийн 70 хувь, Магадлан итгэмжлэгдсэн, их дээд сургуулийн магистр, докторын түвшний сургалтын төлбөрийн 40 хувь” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

4. Тайлант онд 50.7 сая төгрөгөөр бичиг хэргийн материал, 101.0 сая төгрөгөөр аж ахуйн материал, 40.3 сая төгрөгөөр бусад хангамж материалыг тендер зарлалгүй шууд худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д "харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар", 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

5. Шилэн дансны мэдээллийн санд 163 мэдээлэл оруулахаас 3 оруулаагүй, 93 хугацаа хоцроосон, 67 хугацаандаа мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн

6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 149,186.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн татаасаар санхүүжүүлж буй байгууллагуудын санхүүжилтийн гүйцэтгэл, төлбөрийн хяналтын хэлтсийн тусламж үйлчилгээний зардлын хяналтын үйл ажиллагаа, түүний анхан шатны баримт, сангийн программ хангамжийн өгөгдөл хянах, боловсруулах үйл ажиллагааг дараагийн аудитаар авч үзэх асуудал гэж үзэж байна.

2. Эрүүл мэндийн даатгалын тухай /Шинэчилсэн найрууллага/ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.3-д заасан "Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, зарцуулах, банканд хадгалуулах журам"-д Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 22 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж дээрх журмын 4 дүгээр зүйлийн 4.2.2-д "Хүн амыг олноор хамарч удаан хугацааны эмчилгээ, зардал шаардагдах өвчин, халдварт цах тахлын тархалтыг таслан зогсооход шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эм, эмийн хэрэгсэл, урвалж, оношлуур, багаж, тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэх" гэж заасныг үндэслэн 2020 оны эрсдэлийн сангийн хөрөнгөөс 9,600.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын дансанд тусгаарлан 2021 онд 16 аймаг, 2 дүүрэгт "Хүчил төрөгчийн бэсрэг үйлдвэрийн баллон" барих ажилд зарцуулахаар тендер зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулах ажил хийгдэж байна. Мөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг санхүүжүүлдэг байгууллага төлөвлөөгүй хөрөнгө оруулалтын шинжтэй ажлыг дүрэм, журамд өөрчлөлт оруулан зарцуулж байгаа нь анхаарал татахуйц чухал асуудал гэж үзэж байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Авлагатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Өмнөх онуудад үүссэн Капитал банкны 135,290.0 сая төгрөг, НДЕГ-ын 9,467.7 сая төгрөг, бусад 5 байгууллагын 16.2 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын хяналт шалгалтаар 3 аж ахуй нэгжид тогтоосон 1,675.1 сая төгрөг, нийт 146,449.0 сая төгрөгийн авлагын авлагын үлдэгдэлтэй байна.

1.2. Эрсдэл: Олон жилийн насжилттай, материаллаг дүнгээр санхүүгийн тайланд илэрхийлэгдэх авлага үүсэх

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуульд нийцүүлэн авлага үүсгэхгүй ажиллах, барагдах боломжтой авлагыг бууруулах ажлыг зохион байгуулж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Хөрөнгөтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Эзэмших эрхийн зориулалттай 414.0 м2 газрыг санхүүгийн тайланд "газар" дансанд 13.7 сая төгрөгөөр бүртгэж, тайлагнасан. Худалдаж авсан 15.5 сая төгрөгийн 15 нэр төрлийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, тайлагнаагүй.

2.2. Эрсдэл: Хөрөнгийг хууль, журамд нийцүүлэх санхүүгийн тайлан, бүртгэлд тусгах.

2.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2016 оны 19 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг санхүүгийн тайлагналын зориулалттай дахин үнэлэх аргачлалын дагуу санхүүгийн тайланд газрыг бүртгэж тайлагнах талаар зөвлөмж өгөх.

3. Өглөгтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Эрүүл мэндийн даатгалын сан нь нийслэлийн нийгмийн даатгалын газарт 1,077.5 сая төгрөг, Дархан-Уул аймагт 757.6 сая төгрөг, Хөвсгөл аймагт 434.7 сая төгрөг, Ховд аймагт 177.3 сая төгрөг, Сэлэнгэ аймагт 90.2 сая төгрөг, Дорноговь аймагт 9.1 сая төгрөг, нийт 2,546.6 сая төгрөгийн төр хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын өглөг бүртгэлтэй байгаа нь 2017 оноос тайлант он хүртэл талууд барагдуулах арга хэмжээ зохион байгуулж ажиллаагүй улмаас өглөг буураагүй байгаа нь "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Эрсдэл: Олон жилийн насжилттай, материаллаг дүнгээр санхүүгийн тайланд илэрхийлэгдэх өглөг үүсэх

3.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуульд нийцүүлэн өр үүсгэхгүй ажиллах

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4. Зардлын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй ажиллагсад ур чадвар, хоол унааны нэмэгдэл олгосон байна. Үүнд: Урамшуулал 8.5 сая төгрөг, ур чадварын нэмэгдэл 14.9 сая төгрөгийг тус тус олгосон байна.

4.2. Эрсдэл: Хөдөлмөрийн тухай хууль, ЭМДЕГ-ын хөдөлмөрийн дотоод журамд нийцээгүй тушаал гаргаж, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах.

4.3. Өгсөн зөвлөмж: Ажилчидтай хийсэн хөдөлмөрийн гэрээ, тушаал шийдвэрийг хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн байгуулж ажиллах

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

5. Зардлын данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт: Тайлант оны эцэст татвар, нийгмийн даатгалын шимтгэлд 137.8 сая төгрөг илүү шилжүүлж авлага үүсгэсэн байна.

5.2. Эрсдэл: Санхүүгийн асуудал эрхэлсэн дээд болон доод албан тушаалтан хоорондын бүртгэлээр тавих дотоод хяналт хэрэгжихгүй байх, санхүүгийн тайланд ажил, гүйлгээг алдаатай буруу толилуулах, эрх бүхий албан тушаалтныг буруу мэдээллээр хангах.

5.3. Өгсөн зөвлөмж: Зөрчлийг давтан гаргахгүй байх, аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

6. Батлагдсан төсөв гүйцэтгэлтэй холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт: Байр ашиглалтай холбоотой тогтмол зардлын төлөвлөгөөг 157.0 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 54.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 1,015.5 сая төгрөгөөр төлөвлөж 831.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь төсвийг үнэн зөв бодитой төлөвлөхгүй байна.

6.2. Эрсдэл: Төсвийн тухай хуульд заасан төсвийн зарчмыг хэрэгжүүлэхгүй байх,

6.3. Өгсөн зөвлөмж: Төсвийг үнэн бодитой, үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2021

Аудитын
нэр:

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны
жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудит

Аудитын код:

САГ-2020/19/СТА-ЗГТС

Шалгагдсан
байгууллагын нэр:

Эрүүл мэндийн даатгалын сан

Сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
		2	3	4	5
1	Өмнөх оноос шилжиж ирсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас авах төр төлбөрийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын 26,501.2 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй.	26,501.2	Албан шаардлага	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга,	Г.Баясгалан, Б.Болормаа
2	Тайлант оны эцэст 13.4 сая төгрөгийн шатахуун худалдан авч нөөц үүсгэсэн байна.	13.4	Албан шаардлага	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга, үйл ажиллагааны ахлах нягтлан бодогч	Л.Бямбасүрэн, Л.Нарантуяа Н.Дэлгэрмаа
3	Жилийн сургалтын төлөвлөгөө, байгууллага, албан хаагч хоорондын гэрээгүй хичээл үйлдвэрлэл, дадлын зардлаас 26.0 сая төгрөгийн 10 их, дээд сургуулийн төлбөрийг санхүүжүүлсэн. Үүнээс байгууллагын дотоод журамд нийцэхгүй TOEFL-ын сургалтын төлбөр 4.0 сая төгрөгийн зориулалт бусаар зарцуулсан байна.	4.0	Албан шаардлага	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга,	Г.Баясгалан, Б.Батдаваа
4	Тайлант онд 50.7 сая төгрөгөөр бичиг хэргийн материал, 101.0 сая төгрөгөөр аж ахуйн материал, 40.3 сая төгрөгөөр бусад хангамж материалыг тендер зарлалгүй шууд худалдан авалт хийсэн байна.	192.1	Албан шаардлага	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга, үйл ажиллагааны ахлах нягтлан бодогч	Г.Баясгалан, Б.Батдаваа
5	Шилэн дансны мэдээллийн санд 163 мэдээлэл оруулахаас 3 оруулаагүй, 93 хугацаа хоцроосон, 67 хугацаандаа мэдээлсэн байна.	-	Албан шаардлага	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга,	Г.Баясгалан, Б.Болормаа Б.Батдаваа
6	Өмнөх онуудад үүссэн Капитал банкны 135,290.0 сая төгрөг, НДЕГ-ын 9,467.7 сая төгрөг, бусад 5 байгууллагын 16.2 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын хяналт шалгалтаар 3 аж ахуй нэгжид тогтоосон 1,675.1 сая төгрөг, нийт 146,449.0 сая төгрөгийн авлага байна.	146,449.0	Зөвлөмж		

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

7	Эзэмших эрхийн зориулалттай 414.0 м2 газрыг санхүүгийн тайланд "газар" дансанд 13.7 сая төгрөгөөр бүртгэж, тайлагнасан. Худалдаж авсан 15.5 сая төгрөгийн 15 нэр төрлийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, тайлагнаагүй.	29.2	Зөвлөмж	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга, үйл ажиллагааны ахлах нягтлан бодогч	Л.Бямбасүрэн, Л.Нарантуяа Н.Дэлгэрмаа
8	Эрүүл мэндийн даатгалын сан нь нийслэлийн нийгмийн даатгалын газарт 1,077.5 сая төгрөг, Дархан-Уул аймагт 757.6 сая төгрөг, Хөвсгөл аймагт 434.7 сая төгрөг, Ховд аймагт 177.3 сая төгрөг, Сэлэнгэ аймагт 90.2 сая төгрөг, Дорноговь аймагт 9.1 сая төгрөг, нийт 2,546.6 сая төгрөгийн төр хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын өглөг бүртгэлтэй байгаа нь 2017 оноос тайлант он хүртэл талууд барагдуулах арга хэмжээ зохион байгуулж ажиллаагүй улмаас санхүүгийн тайланд материаллаг дүнгээр толилуулж, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.	2,546.6	Зөвлөмж	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга,	Г.Баясгалан, Б.Болормаа
9	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй ажиллагсад ур чадвар, хоол унааны нэмэгдэл олгосон байна. Үүнд: Урамшуулал 8.5 сая төгрөг, ур чадварын нэмэгдэл 14.9 сая төгрөгийг тус тус олгосон байна.	23.5	Зөвлөмж	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга	Г.Баясгалан
10	Тайлант оны эцэст татвар, нийгмийн даатгалын шимтгэлд 137.8 сая төгрөг илүү шилжүүлж авлага үүсгэсэн байна.	137.8	Зөвлөмж	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга, үйл ажиллагааны ахлах нягтлан бодогч	Л.Нарантуяа Н.Дэлгэрмаа
11	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардлын төлөвлөгөөг 157.0 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 54.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 1,015.5 сая төгрөгөөр төлөвлөж 831.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь төсвийг үнэн зөв бодитой төлөвлөхгүй байна.	-	Зөвлөмж	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга, үйл ажиллагааны ахлах нягтлан бодогч	Г.Баясгалан, Б.Болормаа
ДҮН		175,896.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 449/А0190064

Улаанбаатар хот

САГ-2021/19/СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оноос шилжиж ирсэн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын 26,495,356,151.52 /Хорин зургаан тэрбум дөрвөн зуун ерэн таван сая гурван зуун тавин зургаан мянга нэг зуун тавин нэгэн/ төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2-т "Өр, авлага үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах", 20.2.6-т "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үүссэн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дугаар сарын 01-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Л.Нарантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Я.САМБУУНЯМ
П.АМАРСАНАА
Э.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264234

119.10.10.20190109_KhorigAster_Zhandbaga202116321aadbc-2-8_Goan-4-1.Docx

80801



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 448/АД170064

Улаанбаатар хот

САГ-2021/19/СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын дотоод журамд заагдсаны дагуу ажиллагсдын их, дээд сургуульд сурсны төлбөрийг олгохдоо сургалтын төлөвлөгөөг үндэслэн гэрээ байгуулаагүй байна. Мөн журамд заагаагүй TOEFL /гадаадын их дээд сургуульд элсэх/ англи хэлний шалгалтын төлбөр 4,000,000 /Дөрвөн сая/ төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.3.1-т "Анхан шатны баримт бүрдүүлэх", Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлах тухай 2020 оны А/141 дүгээр тушаалын 9.9.1-т "Удирдлагын академи болон төрийн өмчит, их дээд сургуулийн мэргэшүүлэх, магистр, докторын түвшний сургалтын төлбөрийн 70 хувь, Магадлан итгэмжлэгдсэн, их дээд сургуулийн магистр, докторын түвшний сургалтын төлбөрийн 40 хувь" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээд шатны төсөв захирагчийн гаргаж авсан тушаал, шийдвэрийг мөрдөж ажиллах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, зохион байгуулсан ажил, үйлчилгээний анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Л.Нарантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Я.САМБУУНЯМ
П.АМАРСАНАА
Э.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

1:10.10.2020 10:49:10 -> D:\erug-elban-shaardlaga\2021\0325\audit\1.8\Огноо-43.docx

680804

